

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 10 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 10 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	2010-IX	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-X
1	Даатгалын компани	16			16
2	Даатгалын компанийн салбар	136	1 ¹		137
3	Даатгалын төлөөлөгч	1998	24 ²		2022
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	6			6
6	Актуарч	10	1 ³		11
7	Бусад		5 ⁴		

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2010 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 142 дугаар тушаалаар “Лоялти солиушн” ХХК-д Дорнод аймагт салбар нээхийг зөвшөөрсөн.

²Хорооны даргын 2010 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 146 дугаар тушаалаар “Номин даатгал” ХХК-ийн 24 төлөөлөгчид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон.

³Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор Б.Хүрэлбаатарт ердийн болон урт хугацааны даатгалын актуарчийн үйл ажиллагаа явуулах эрх олгосон.

⁴Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монгол даатгал” ХХК-ийн Даатгал эрхэлсэн дэд захирлын албан тушаалд Т.Тэлмэн, Бодлого зохицуулалт эрхэлсэн дэд захирлын албан тушаалд С.Ганчимэг, Эрх зүй, нөхөн төлбөр эрхэлсэн дэд захирлын албан тушаалд Я.Энхбаяр нарыг тус тус томилохыг зөвшөөрсөн.

⁴Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 275 дугаар тогтоолоор “Практикал даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,100.0 сая төгрөг болгон тогтоохыг зөвшөөрсөн.

⁴Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 276 дугаар тогтоолоор “Тэнгэр даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 500.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000.0 сая төгрөг болгон тогтоохыг зөвшөөрсөн.

⁴Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 277 дугаар тогтоолоор “Мөнх даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 513.0 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 1,000.0 сая төгрөг болгон тогтоож, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

⁴Хорооны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 278 дугаар тогтоолоор “Мөнх даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн даргын албан тушаалд Ч.Отгонжаргал, гишүүдэд Р.Нямсүрэн, Ч.Жигжид нарыг томилохыг зөвшөөрсөн.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын байгууллагуудын 2010 оны 10 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2009-Х	2010-Х
1	Даатгалын нийт хураамж	1,598,526,212.4	1,537,251,404.6
2	Олгосон нийт нөхөн төлбөр	392,846,843.8	364,750,707.2
3	Давхар даатгалд төлсөн хураамж	613,250,920.0	670,300,010.9
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	5,201.0	4,482.0
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	16,917,643,340.8	22,739,296,272.2
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	43,347,824.7	45,913,620.0

2010 оны 10 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 61.3 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 28.1 сая төгрөгөөр тус тус буурч, давхар даатгалд төлсөн хураамж 57.0 сая төгрөгөөр өссөн байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа



Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2009-Х	2010-Х
1	Даатгалын нийт хураамж	11,088,123.0	17,387,131.0
2	Олгосон нийт нөхөн төлбөр	1,000,000.0	5,177,779.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж	3,816,265.5	-
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	19	6
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд		3
	-Байгууллагын хугацаат даатгалд		3
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		-
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		-
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	20,000,000.0	20,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	1,000,000.0	403,000.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 10 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 6.3 сая төгрөгөөр, нөхөн төлбөр 4.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2010-VIII	2010-IX	2010-X
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	40,106,149.5	33,275,321.4	21,348,153.3
2	Даатгалын зуучлагчийн орлого	18,341,972.8	14,192,906.4	6,459,185.1
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	22	60	6
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	15,959,225,000.0	3,650,768,510.9	3,818,051,962.6

2010 оны 10 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 6 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучлан 6.5 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.